

“АРИГ ГАЛ” ХК
ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ

2018 оны 04 дүгээр сарын
25- ны өдөр

Дугаар 01.18

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн саналын
тооллогын дүнг батлах тухай

Монгол улсын “Компанийн тухай хууль”-ийн 63 дугаар зүйлийн 63.4, 63.5 дугаар заалт, 72 дугаар зүйлийг удирдлага болгон “Ариг гал” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2018 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн ээлжит хурлаар хэлэлцсэн асуудлаар хувьцаа эзэмшигчдээс санал хураах хуудсаар өгсөн нууц санал хураалтад явуулсан тооллогын дүнгийн тухай тооллогын комиссын 01.18 тоот тэмдэглэлийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 2888347 санал буюу ердийн олонхийн 100.0%-ийн саналаар Компанийн 2017 оны үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагааны талаарх гүйцэтгэх захирлын тайланг, 2888347 санал буюу ердийн олонхийн 100.0%-ийн саналаар Компанийн жилийн үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагаанд ТУЗ -өөс өгсөн дүгнэлтийг батлах,

2. Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 2889183 санал буюу кумулятив 16.8%-ийн саналаар С.Мөнхжаргалыг, 2888301 санал буюу кумулятив 16.7%-ийн саналаар Д.Гивапилыг, 2888299 санал буюу кумулятив 16.7%-ийн саналаар Д.Мөнхбатыг, 2888314 санал буюу кумулятив 16.7%-ийн саналаар С.Алимааг, 2888298 санал буюу кумулятив 16.7%-ийн саналаар Б.Ёндонжамцыг, 2888297 санал буюу кумулятив 16.7%-ийн саналаар Х.Ханияг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн энгийн гишүүнээр,

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 2888726 санал буюу кумулятив 33.34%-ийн саналаар Б.Болдыг, 2888289 санал буюу кумулятив 33.33%-ийн саналаар Б.Аюушийг, 2888279 санал буюу кумулятив 33.33%-ийн саналаар Э.Бямбажавыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүнээр,

3. Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 2888292 санал буюу ердийн олонхийн 99.99%-ийн саналаар 2017 оны ашгаас нэгж хувьцаанд 21.33 төг, буюу нийт 74.2 сая.төг (далан дөрвөн сая хоёр зуун мянган)-ийг Ногдол ашигт олгохоор,

4. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцогчдын 2888303 санал буюу ердийн олонхийн 99.99%-ийн саналаар компанийн удирдлагын зардлыг 52298.0 мянган төгрөг (тавин хоёр сая хоёр зуун ерэн найман мянган) өөр батлахаар тус тус өгсөн саналын тооллогын дүнг ХЭХ-д оруулж батлуулсугай.

5. Хуралд оролцогчдын саналын тооллогын дүнг хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж батлуулахыг Тооллогын комиссын дарга (Б.Цолмон)-д даалгасугай.

Тооллогын комиссын дарга :




(Б.Цолмон)

Тооллогын комиссын гишүүд :

(Д.Мөнхбаатар)

(Э.Тогосмаа)



“АРИГ ГАЛ” ХК
ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 04 дүгээр сарын
25- ны өдөр

Дугаар 01.18

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн саналын
дүнг батлах тухай

Монгол улсын “Компанийн тухай хууль”-ийн 63 дугаар зүйл, “Ариг гал” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2018 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын 01.18 тоот тогтоолыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 2888347 санал буюу ердийн олонхийн 100.0%-ийн саналаар Компанийн 2017 оны үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагааны талаарх гүйцэтгэх захирлын тайланг, 2888347 санал буюу ердийн олонхийн 100.0%-ийн саналаар Компанийн жилийн үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагаанд ТУЗ -өөс өгсөн дүгнэлтийг батласугай.

2. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, “Компанийн тухай хууль”-ийн 83 дугаар зүйлд заасан эрх үүргийг хэрэгжүүлж, компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдлага зохион байгуулалтаар хангаж ТУЗ-д ажлаа дүгнүүлж ажиллахыг гүйцэтгэх захирал (Х.Хания)-д үүрэг болгосугай.


Хурлын дарга

Д.Мөнхбат

Тооллогын комиссын дарга

Б.Цолмон





“АРИГ ГАЛ” ХК
ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 04 дүгээр сарын
25-ны өдөр

Дугаар 03.18

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах тухай.

“Компанийн тухай хууль”-ийн 46 дугаар зүйл, Компанийн ногдол ашгийн бодлогын тухай журам, ТУЗ-ийн 2018 оны 02 дугаар сарын 19-ны өдрийн 01.18 тоот тогтоолоор гаргасан шийдвэр, хувьцаа эзэмшигчдийн 2018 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын 01.18 тоот тогтоол, хувьцаа эзэмшигчдийн хурлын 01.18 тоот тэмдэглэлийн шийдвэрлэсэн нь хэсгийн 3-д заасныг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 288292 санал буюу дийлэнх олонхийн 99.99 %-ийн саналаар 2017 оны ашгаас нэгж хувьцаанд ногдох ашгийг 21.33 төг-өөр тогтоосугай.

2. Ногдол ашигт зарцуулагдах 74.2 сая.төг (далан дөрвөн сая хоёр зуун мянган)-ийг компанийн хуримтлагдсан ашгаас гаргахыг гүйцэтгэх захирал (Х.Хания)-д зөвшөөрсүгэй.

3. Компанийн мөнгөн гүйлгээний боломжтой үед зохицуулан Ногдол ашгийг нийтэд зарлах хугацааны саналаа ТУЗ-д оруулж шийдвэрлүүлэн хувьцаа эзэмшигчдэд тараах ажлыг зохион байгуулан гүйцэтгэхийг гүйцэтгэх захирал /Х.Хания/-д даалгасугай


Хурлын дарга

Тооллогын комиссын дарга



Д.Мөнхбат

Б.Цолмон



“АРИГ ГАЛ” ХК
ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 04 дүгээр сарын
25-ны өдөр

Дугаар 04.18

Улаанбаатар хот

Компанийн удирдлагын зардлыг
батлах тухай.

“Компанийн тухай хууль”-ийн 63.1.13-дугаар зүйл, хувьцаа эзэмшигчдийн 2018 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын 01.18 тоот тогтоол, хувьцаа эзэмшигчдийн хурлын 01.18 тоот тэмдэглэлийн шийдвэрлэсэн нь хэсгийн 4 дэхь заалтыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн удирдлагын зардлын төсвийг хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 2888303 санал буюу ердийн олонхийн 99.99 %-ийн саналаар 52298.0 мянган төгрөг (тавин хоёр сая хоёр зуун ерэн найман мянган) өөр хавсралтын дагуу баталсугай.

2. Батлагдсан төсөвт багтаан компанийн удирдлагын зардлыг санхүүжүүлэхийг гүйцэтгэх захирал (Х.Хания)-д, зардлын зарцуулалтын үнэн зөв байдалд хяналт тавьж, удирдлагаар хангаж ажиллахыг ТУЗ-ийн дарга (С.Мөнхжрагал) –д тус тус даалгасугай.

Хурлын дарга

Тооллогын комиссын дарга



Д.Мөнхбат

Б.Цолмон